

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.12

Өлгий сум

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, хангаж буй талаар.

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/81 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор 16 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр баталж, хэрэгжилтийг 80.0 хувьтай хангасан.

2. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийг 2022 оны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт, 15 төрлийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх 17 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталж, хэрэгжилтийг 88.0 хувьтай хангасан.

3. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийг 2022 оны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэж, Цагдаагийн газрын 2022 оны 5 зорилттой 52 заалт бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хянуулж, хэрэгжилтийг 88.5 хувьтай хангасан.

4. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн “Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” А/197 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгүүдийг шинэчлэн баталсантай холбоотой Цагдаагийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/41 дугаар тушаалаар “Цагдаагийн газраас 2022 онд хяналтанд авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ыг шинэчилж, хэрэгжилтийг хангах, тогтоосон хугацаанд тайлагнахыг эрх бүхий албан тушаалтнуудад хариуцуулсан ба шинэчилсэн жагсаалтын дагуу 79 төрлийн баримт бичгийг хяналтанд авч Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Цагдаагийн ерөнхий газар, холбогдох алба, нэгжүүдэд тайлагнасан.

5. Дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг алба хаагч нэг бүрт хүргэх, ялангуяа сумдад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад тухай бүрт нь хүргэн судлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, үүрэг, ажлын чиглэлийн нэгдсэн бүртгэл хөтөлж баримт үйлдэх, тайлагнах үүрэг бүхий орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны А/67 дугаар тушаалаар байгуулан тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 4, Тэргүүн дэд

даргын 50, Дэд даргын 65, нийт 119 төрлийн даалгавар, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтнаас ирүүлсэн 99 төрлийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, зааварчилгаа, мэдээллийг алба хаагч нэг бүрт хүргэж, хэрэгжилтийг хангуулан тогтоосон хугацаанд тайлагнасан.

6. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан 6 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг 88.3 хувьтай хангасан.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 9 төрлийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

7. Цагдаагийн газрын тасаг, хэсгийн үйл ажиллагааг шалгах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зааварчлах, хэвийн үйл ажиллагааг хангах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах /код-112/ журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн газрын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулсан.

8. Цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилтыг хангуулах, аюулгүй байдлыг хангах, сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг, ажлын чиглэл 19, зааварчилгаа 26, зөвлөмж 6, баталгаа 25, мэдэгдэх хуудас 10, бие бүрэлдэхүүний нэгдсэн цугларалтын үед 264 удаа үүрэг, ажлын чиглэл өгч хэрэгжилтийг хангуулсан.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хуралдаан тайлангийн хугацаанд хуралдсан байдал, шийдвэрлэсэн асуудлын талаар.

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Даргын зөвлөл байгуулах, асуудал хэлэлцэх /код-104/ журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах 13 ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулсан ба Цагдаагийн газрын даргын зөвлөл 15 удаа хуралдаж, цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар 64, хүний нөөцтэй холбоотой 67, нийт 131 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн ба шийдвэрлэсэн асуудлын талаарх мэдээллийг алба хаагчдад тухай бүрт нь танилцуулж, мэдээ, мэдээллээр хангасан.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” болон “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих стандарт”, Монгол Улсын стандарт /MNS5140:2021/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/24 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Архив, албан хэрэг хөтлөх /код 120/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын дагуу Цагдаагийн газрын даргын хүний нөөц, алба хаагчдад холбоотой гаргасан А тушаал 70, цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой гаргасан Б тушаал 112, нийт 182 тушаалыг холбогдох хууль тогтоомж, журмыг үндэслэн боловсруулан гаргасан.

1.3. Хүний нөөцийн бодлогын талаар:

1. Төрийн албаны тухай болон Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон хүний нөөцийг төлөвлөх, сонгон шалгаруулах, бүрдүүлэх, бэлтгэх, хуваарилах, үнэлэх, оновчтой байршуулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/199 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангасан.

2. Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолт боловсруулах /код 106/ журам”-ын дагуу тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах болзол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг шинээр баталгаажуулсан албан тушаалын тодорхойлолтуудыг алба хаагч бүртэй танилцуулан хэрэгжилтийг хангуулсан.

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн “Аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн нэршил өөрчлөх, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/293 дугаар тушаалаар баталсан зохион байгуулалтын бүтэцийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

4. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/179 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тооцох журам”, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсээс 2021 оны 3/447 дугаартай албан бичгээр ирүүлсэн ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн дагуу “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын 2022 оны А/08 дугаартай тушаалаар 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх орох иргэний сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалтыг зохион байгуулж, нийт бүртгэгдсэн 14 иргэнээс нягтлан бодогч мэргэжилтэй-1, эмч мэргэжилтэй-3, эрх зүйч-2, нийт 6 иргэн тэнцсэн бөгөөд өнөөдрийн байдлаар хүний нөөцөд 12 иргэн бүртгэлтэй байна.

- Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн “Мэдээлэл хүргүүлж, бүртгэлийн ажлыг эхлүүлэх тухай” 3/257 дугаартай албан бичгийн дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн нөхөн хангалт, нөөц бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан зохион байгуулсан “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтын бүртгэл, судалгааг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд Цагдаагийн газрын даргын 2022 оны А/45 дугаартай тушаалаар байгуулагдсан 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг зохион байгуулсан бөгөөд нийт 5 иргэн бүртгүүлсэнээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тооцох журам”-ын дагуу болзол шалгуурыг хангасан дээрх 5 иргэнийг шалгалтанд хамруулж, холбогдох материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

6. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулах, шалгалт авах, нөөцөд бүртгэх, дэвшүүлэн томилох /код-909/ журам”-ын дагуу албан тушаал дэвшүүлэх нөөцийн нэгдсэн жагсаалтанд 24 алба хаагчийг хэлтэс, тасаг, хэсэг, ахлах албан тушаал болон офицерийн албан тушаалд тус тус бүртгүүлсэн.

7. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, дотоодын цэргийн штабын дарга болон Цагдаагийн газрын даргын тушаалаар 51 алба хаагчид цол олгосон.

Төрийн дээд одон медалиар 1, Засгийн газрын салбарын “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 3, Цагдаагийн гавьяа тэмдгээр 2, Цагдаагийн ерөнхий газрын “Хүндэт жуух”-аар 8, албадын шагналаар 3, Дотоодын цэргийн шагналаар 2, бусад шагналаар 5, нийт 25 алба хаагч шагнагдсан нь нийт алба хаагчдын 16.6 хувийг эзэлж байгаа бөгөөд шагналыг Цагдаагийн ерөнхий газарт уламжлуулан холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, шаардлага, шалгуурт үндэслэн шийдвэрлүүлсэн.

8. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 72 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн

төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код-111/ журам”-ын 111.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн 1, 3 дугаар улирлын явцын ярилцлагыг 4, 10 дугаар сарын 5-ны дотор хийж, хагас, бүтэн жилээр ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн.

Цагдаагийн газрын алба хаагчдын 2022 оны эхний хагас жил, сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээг баталгаажуулах үнэлгээний багийг Цагдаагийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн өдрийн А/36, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн өдрийн А/69 дүгээр тушаалаар тус тус байгуулж, алба хаагч, ажилтны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хагас, бүтэн жилийн тайланг хянаж, үнэлгээ өгч, баталгаажуулсан.

9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох /код 944/ журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Цагдаагийн газрын дасан зохицох үйл ажиллагааны хөтөлбөр, Цагдаагийн газрын дасан зохицох үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх /дадлагажих/ төлөвлөгөө, алба хаагчдын дадлагажиж буй үйл ажиллагааг бодитой үнэлж дүгнэх, шалгуур үзүүлэлт, үнэлгээний хуудсыг тус тус баталж, тайлангийн хугацаанд 6 алба хаагчдад халамжлан хүмүүжүүлэгч, дадлагажуулагч багшийг Цагдаагийн газрын даргын 2022 оны Б/21, Б/22, Б/51, Б/83, Б/91, Б/109 дүгээр тушаалаар тус тус томилж ажиллуулсан бөгөөд шинээр томилогдсон алба хаагчид хариуцсан ажилдаа богино хугацаанд дасан зохицоход шууд нөлөөлж байна.

10. Сумын Засаг дарга нараас ирүүлсэн саналыг үндэслэн Цагдаагийн газрын даргын 2022 оны Б/16, Б/76, Б/92, Б/93 дугаар тушаалаар 4 олон нийтийн цагдааг томилон хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт хариуцуулан ажиллуулсанаар алба хаагчдын ажлын ачаалал буурах, үүрэг гүйцэтгэх чадвар нэмэгдэхэд нөлөөлсөн болно.

11. Цагдаагийн газраас 2022 онд сахилгын шийтгэлгүй 7 алба хаагчийг Дотоод хэргийн их сургуулийн магистрын болон эчнээ 3 жилийн сургалтанд 2022 оны 09 дүгээр сараас тус тус суралцуулж эхэлсэн. /Магистрын сургалтанд 3, эчнээ ангид 4 алба хаагч/

1.4. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/07 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын төлөвлөгөө”-г баталсан бөгөөд 2022 онд 41 төрлийн сэдвийн хүрээнд 131 цагийн 127 удаагийн сургалтыг 12 сургагч багш нар болон эрдмийн зэрэгтэй /магистрын зэрэгтэй 12 алба хаагч/ алба хаагчид зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 85 хувьтай хангагдсан.

2. Цагдаагийн газраас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах /код 951/ журам”-ын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор албаны сургалтыг нэгдсэн болон тасаг, хэсгийн дотоод сургалт зэрэг хэлбэрээр болон мэдвэл зохих хууль тогтоомж, хөгжүүлэх, дадлагажих, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт зэрэг чиглэлээр зохион байгуулсан.

3. Цагдаагийн газраас тайлангийн хугацаанд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 34 удаа 37 цаг, алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 19 удаа 27 цаг,

дадлагажуулах сургалтыг 5 удаа 6 цаг, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах 8 удаагийн 8 цаг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 13 удаа 34 цагийн сургалт нийт 82 удаагийн 112 цаг сургалт явуулсан ба давхардсан тоогоор 9944 алба хаагчийг танхим болон цахим хэлбэрээр хамрууллаа.

4. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны А/20 дугаар тушаалаар баталсан “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор цагдаагийн газрын соён гэгээрүүлэх 18 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталж, хэрэгжилтийг 85 хувьтай ханган ажилласан. Тухайлбал:

- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр зохион байгуулсан 63 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор хамрагдсан 8353 алба хаагч, соёл, хүмүүжлийн чиглэлээр зохион байгуулсан 45 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 5189 хамрагдсан алба хаагч, нийт зохион байгуулсан 97 удаагийн ажил, арга хэмжээнд хамрагдсан 13542 алба хаагчийг харуулсан болно.

1.5. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар.

1. Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх 14 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлан хэрэгжилтийг хангуулсан. Тухайлбал:

2. Цагдаагийн газрын алба хаагч, ахмад ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус аймгийн Толбо сумын нутаг дэвсгэрээс амралт, сувилалын газар байгуулахад шаардлагатай 3000м² газрыг Толбо сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/28 дугаар газар эзэмшүүлэх захирамжаар шийдвэрлүүлсэн.

- Цагдаагийн газрын нийт 70 гаруй ахлагч бүрэлдэхүүний гэр бүлийн хэрэгцээнд зориулж тус аймгийн Бугат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 34.996 м² газрыг эзэмшилд авсан болно.

3. “Хамт олны дундын сан”-ийн ажлын хэсэг зохих журмын дагуу гэр бүл, хүүхэдтэй болсон, эмнэлэгт хэвтэж эмчилгээ хийлгэсэн, өөрөө болон гэр бүлийн гишүүн эхнэр, хүүхэд нь Улаанбаатар хотод эмчилгээнд явж ирсэн мөн тэдний аль нэгийг сахин хэвтсэн, ар гэрийн гачигдал тохиолдсон алба хаагч нарт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор нийт 54 алба хаагчдад 10.464.100 орчим төгрөгний мөнгөн хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлсэн.

4. Хэсгийн төлөөлөгч нарын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сум хариуцсан мөрдөгч нарыг цагдаагийн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар тасгийн дарга нарт хариуцуулан тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлээд байна.

- Сум дахь цагдаагийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч /сум хариуцсан эрүүгийн мөрдөгч/, цагдаа нарыг үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор удирдамжийн дагуу давхардсан тоогоор 28 суманд ажилласан.

- Хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын ажиллах амьдрах нөхцөлийг сайжруулах, сумын удирдлагуудтай хамтран ажиллах зорилгоор Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарын хамтарсан “Гурвалсан гэрээ”-г 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан.

- Тайлангийн хугацаанд 5 сум, 1 тосгоны төвийг хяналтын камерын нэгдсэн системд холбоход шаардагдах 31.000.000 төгрөгийг шийдвэрлэсэн бөгөөд хяналтын камерын нэгдсэн системд холбох ажил хийгдсэн.

- Мөн гэрээний хүрээнд сумын удирдлагуудтай хамтран ажилласны үр дүнд 3 сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг автомашинтай болгох ажлыг зохион байгуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 12 сум, 1 тосгоноос 9 сумын хэсгийн төлөөлөгч авто машинаар хангагдаад байна.

- Тус цагдаагийн газарт цагдаагийн 13 кобан бүртгэлтэй байгаа бөгөөд 1 сумын цагдаагийн кобаныг төвлөрсөн дулааны шугамд холбох ажлыг сумын удирдлагуудтай хамтран хэрэгжүүлсэнээр 6 сумын цагдаагийн кобан төвлөрсөн дулааны шугамд холбогдлоо.

- Сумдын цагдаагийн кобаны барилгад засвар үйлчилгээ хийх, алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин, үүрэг гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 сумын цагдаагийн кобаны засварын ажилд 20.500.000 төгрөг тусгуулан засвар үйлчилгээ хийсэн.

5. Нийт 61 алба хаагчийн цалингийн шатлалыг ахиулж, 13 алба хаагчийн төрийн тусгай алба хаасны хугацааны нэмэгдэл тооцож сар бүр олгосон.

- Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 1 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг олгуулсан.

- Тус Цагдаагийн газарт бусад цагдаагийн байгууллагаас нийт 13 алба хаагч шилжиж ирсэн бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.3-д зааснаар цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан 1 алба хаагчид энэ оны 9 дүгээр сараас эхлэн ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг одоо мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож олгож эхэлсэн.

6. Алба хаагчдын 2022 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцын ярилцлагыг хийж үр бүтээлтэй ажилласан 32 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг интервалаар 5-40 хувь буюу 5.872.902 төгрөгийг нэмж олгож, алба хаагч нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан.

- Мөн Цагдаагийн газрын алба хаагчдын 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээг баталгаажуулж, нийт 72 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-40 хувиар нэмж /13.280.300 төгрөг/ олгож, алба хаагч нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн.

- Алба хаагчдын 2022 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцын ярилцлагыг хийж үр бүтээлтэй ажилласан 49 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг интервалаар 5-40 хувь буюу 6.902.000 төгрөгийг нэмж олгож, алба хаагч нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан.

7. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг оновчтой, аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлж, үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулан биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий эрсдэлийг удирдах орон тооны бус багийг Цагдаагийн газрын даргын 2022 оны А/64 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан ба Цагдаагийн газрын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг 3 чиглэлээр тодорхойлж, 2022 онд хариу арга хэмжээ авах 20 заалт бүхий ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталж хэрэгжүүлсэн.

8. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор цагдаагийн газраас 12 төрлийн ажил, арга хэмжээний

төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр баталж, хэрэгжилтийг 92.5 хувьтай хангасан.

9. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Алба хаагч, ажилтны сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” чиглэлээр 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор цагдаагийн газраас 2022 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталж, хэрэгжилтийг хангуулсан.

1.6. Нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар.

1. Аймаг, сумын удирдлагууд 2022 онд Цагдаагийн газрын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 257.640.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн.

2. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2022 онд 90.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэнээс цагдаагийн газраас 13 төрлийн ажил, арга хэмжээ зохион байгуулахад 32.400.000 төгрөгний санхүүжилтийг хувиарласан. Тухайлбал:

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2.0 сая, Гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 3.0 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, “Хөршийн холбоо”, “Малчдын бүлэг”, “Өсвөрийн сэргийлэгч”-ийн гишүүдийг шагнаж, урамшуулах ажилд 1,8 сая, үеэр усны аюулаас урьдчилан сэргийлэх ажилд 3.0 сая, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, постор, контент хийх зардалд 2.0 сая, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зардалд 1.2 сая, тус аймагт сүүлийн 5 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох судалгаа хийх зардалд 8.0 сая, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 1.0 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах ухаалаг дэлгэцийн зардалд 8.6 сая, чанга яригчийн зардалд 1.8 сая, нийт 32.4 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэхээр тусгагдсан.

3. Аймгийн Засаг даргад 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 28/438 дугаартай албан бичгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах, харьяа нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаанд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах талаар санал хүргүүлсэн бөгөөд хүргүүлсэн албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/163 дугаар захирамжаар осол, хэрэг давтамжтай бүртгэгддэг, бүртгэгдэж болзошгүй цэгүүдэд 4 ширхэг зурагт самбар босгоход 3.200.000, нарны энергээр ажилладаг маяалкад 1.800.000, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд тараах /зөвлөмж, санамж, сэрэмжлүүлэг/-д 3.750.000, нийт 8.750.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн болно.

4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд хяналтын цэгүүдэд ашиглах хөдөлгөөнт байрыг хийж бэлэн болгох, засварлан тохижуулах ажилд 13.000.000 төгрөгний санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/165 дугаар тушаалаар шийдвэрлэсэн бөгөөд цагдаагийн газрын дансанд бүртгэлтэй ЗИЛ-131 маркийн тээврийн хэрэгслийн тээшийг алба хаагчид үүрэг гүйцэтгэх байдлаар бүрэн засварласан болно.

5. Цагдаагийн газрын гудамж /цэцэрлэгт хүрээлэн/ бий болгох саналыг аймгийн төв Өлгий сумын удирдлагуудад 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 29/167 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Цагдаагийн газрын нэрэмжит гудамж”-ийг бий болгох шийдвэр

гаргуулсан бөгөөд гэрэлт гудамж болгоход шаардагдах 20.000.000 төгрөгний санхүүжилтийг аймгийн төв Өлгий сумын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 29 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн болно.

6. Монгол Улсын Их хурлын дарга Г.Занданшатаргаас олгосон "УАЗ-22069" маркийн авто машиныг тус цагдаагийн газарт УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг нар 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр гардуулсан.

7. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 93 дугаар тогтоолоор орон нутгийн 2021 оны төсвийн давсан орлогоос Цагдаагийн газрын хурлын танхимд 21 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэх 8.100.000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

1.7. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүнгийн талаар.

1. Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, архи дан согтуурахтай тэмцэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Эрүүл зан үйлийг дэмжсэн Архидалтгүй аймаг-Баян-Өлгий-2" 2021-2022 онуудад хэрэгжих дунд хугацааны хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн газраас "Эрүүл зан үйлийг дэмжсэн Архидалтгүй аймаг-Баян-Өлгий-2" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 26 заалт бүхий салбар төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Зан үйлийг дэмжсэн "Архидалтгүй аймаг Баян-Өлгий-2" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 5.000.000 төгрөгийг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/319 дугаартай захирамжаар шийдвэрлүүлж, зориулалтын дагуу зарцуулсан.

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2025 онд хэрэгжүүлэх "Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий" үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 дахь заалт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, хүчирхийллийг бууруулах зорилгоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах" дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 67 дугаар тогтоолоор батлуулан, 2022-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талаар аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/771 дугаар захирамжаар 10.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн.

"Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах" дэд хөтөлбөрийг 2022-2025 оны хооронд хэрэгжүүлэх 17 төрлийн ажлын төлөвлөгөөг батлуулан, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоотой хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

1.8. Тайлангийн хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

1. Цагдаагийн газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалаар 10 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсон Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, зөвлөлөөс гаргасан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, алба хаагч, ажилтны сахилга, ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах, урьдчилан сэргийлэх

санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий зөвлөл 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас авлигын индексийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2022 онд хангах 9 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангуулсан.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 45 ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр баталж, хэрэгжүүлсэн.

3. Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр баталсан “Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө”, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 03/8075 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах сургагч багшийн 2022 оны сүүлийн хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-д тус тус тусгагдсан нийт 18 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тоож, тайлагнасан.

4. Тайлангийн хугацаанд Цагдаагийн газрын алба хаагчдаас гэмт хэрэгт холбогдсон, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан алба хаагч бүртгэгдээгүй.

1.9. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар.

1. Цагдаагийн газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 45 алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 21 өргөдөл, гомдол ирүүлсэн бөгөөд бүртгэлд авч дугаар олгож, албаны шалгалт явуулан хуулийн хугацаанд өргөдөл, гомдол гаргагчид хариуг нь хүргүүлсэн.

Өргөдөл, гомдолд 45 алба хаагчийг холбогдуулан шалгасны 39 буюу 86.6 хувийг офицер, 10 буюу 13.3 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад алба хаагчийн тоо 15, өргөдөл, гомдлын тоо 4-өөр тус тус буурсан.

Төрлөөр нь авч үзвэл: 2 буюу 9.5 хувийг хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 1 буюу 4.7 хувийг цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл, ёс зүй зөрчсөн, 1 буюу 4.7 хувийг бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 4 буюу 19 хувийг ажлын хариуцлага алдсан, 1 буюу 4.7 хувийг архидан согтуурсан, 12 буюу 57.1 хувийг ЭХХШТ хууль болон бусад хууль, дүрэм зөрчсөн гэх зөрчлүүд тус тус эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв” 11-11-д 1, Цагдаагийн ерөнхий газрын алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авах 126 дугаар утсанд 1, нийт 2 гомдол мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд нэг гомдол мэдээлэлд дурдагдсан зөрчил батлагдаж, нэг гомдол мэдээлэлд дурдагдсан зөрчил батлагдаагүй болно.

2. Цагдаагийн газрын удирдлагад хандаж иргэд, алба хаагчдаас 144 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн бөгөөд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/227 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /код 121/ журам”-ын дагуу хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлсэн.

Төрлөөр нь авч үзвэл: 5 буюу 4.7 хувийг ажилд орох, суралцахыг хүссэн, 1 буюу 0.6 хувийг ажилд дахин орохыг хүссэн, 46 буюу 31.9 хувийг ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 42 буюу 29.1 хувийг захиргааны чөлөө хүссэн, 7 буюу 4.8 хувийг тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүссэн, 43 буюу 29.8 хувийг бусад төрлийн өргөдөл, гомдол эзэлж байна.

1.10. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар.

1. Алба хаагч, ажилтны сахилга, ёс зүйн зөрчил болон гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон шалтгаан нөхцөлийг 2021 оны байдлаар судлан шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ерөнхий 12 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж хэрэгжилтийг хангуулсан.

- Цагдаагийн газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалаар алба хаагч, ажилтны сахилга, ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийг 10 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсон.

- Сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийж үзэхэд хувь хүний буруутай үйл ажиллагаа, ёс зүй хангалттай төлөвшөөгүй зэрэг гол шалтгаан нөхцөл тогтоогдсон ба арилгах чиглэлээр төлөвлөгдсөн тодорхой 20 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцов. Тухайлбал:

“Амьдрал ба архи”, “Албаны бэлэн байдлыг шалгах, түргэн цугларалтын дохио өгөх үеэр алба хаагчдын анхаарах асуудал”, “Биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх нь”, “Харилцаа”, “Алдаан дээрээс суралцья” сэдэвт ажлын байран дахь сургалт, “Дүрэмч ажиллагаа-өнгө нэмье”, “Амжилтын төлөө хамтдаа” аян, “Цагдаагийн газрын сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчдтай хийсэн уулзалт”, “Офицер бүрэлдэхүүний зөвлөгөөн, “Ахлагч бүрэлдэхүүний зөвлөгөөн” гэх мэт

- Алба хаагчдын идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, цагдаагийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Цагдаагийн газрын дотоод журмын төслийг 16 бүлэг, 192 заалттай боловсруулж, Цагдаагийн газрын даргын 2022 оны 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Цагдаагийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар цагдаагийн газрын дотоод журмыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

- Прокурорын шаардлагад дурдагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх зорилгоор цагдаагийн газрын нийт мөрдөгч, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны дунд “Алдаагаа засья” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Цагдаагийн газрын хурлын танхимд хооронд зохион байгуулж, прокурорын шаардлагад зөрчил дутагдлыг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

- Цагдаагийн газрын мөрдөгч, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нараас мөрдөн шалгах болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, нийтлэг зөрчлүүдийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газарт 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Алдаагаа засья” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/155 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй Цагдаагийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/42 дугаар тушаалаар байгуулж, 26 заалт бүхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/201 дугаартай тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, Цагдаагийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан цагдаагийн газрын дотоод журмын талаар алба хаагчдад мэдээ, мэдээлэл өгч сургалт зохион байгуулсан.

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/201 дугаартай тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал /код-921/ журам”, Цагдаагийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан Цагдаагийн газрын “Дотоод журам”-ыг тусгагсан зориулсан гарын авлагыг бүтээж, алба хаагчдад олгон судлуулсан.

5. Цагдаагийн газрын тайлант хугацааны сахилга, ёс зүй, хариуцлагын байдлыг бие бүрэлдэхүүнд мэдээлэх, гарсан зөрчлийг шинжлэн хэлэлцэх, сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, алба хаагчийн төлөвшилд нөлөөлөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, асуудлыг хамтын оролцоотойгоор шийдвэрлэх зорилготой Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын “Сахилга, ёс зүй, хариуцлага”-ын зөвлөгөөнийг зохион байгуулсан бөгөөд 1 дүгээр улирлын зөвлөгөөнөөс 6, 2 дугаар улирлын зөвлөгөөнөөс 8, 3 дугаар улирлын зөвлөгөөнөөс 6, нийт 20 шийдвэр гаргасан хэрэгжилтийг хангуулсан.

6. Цагдаагийн газрын Сахилга, ёс зүйн хорооноос алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар тасаг, хэсгийн дарга, дотоодын цэргийн тусгай салааны захирагч нарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 15 заалт бүхий 02/06 дугаартай хэрэгжих боломжтой үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

7. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны “Ёс зүйн төлбөртэй сургалтын хөтөлбөр шинэчлэн баталж, төлбөрийн жишиг хэмжээг тогтоох тухай” А/34 дугаар тушаалын дагуу сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 10 алба хаагчийг “Ёс суртахуун төлөвшил хандлага”, “Мэргэжлийн ёс зүй, хандлага, ур чадварыш дээшлүүлэх” сэдэвт төлбөрт цахим сургалтанд хамруулсан.

8. Сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр бичгээр 10 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зааварчилгаа, зөвлөмж өгч үр дүнг тогтоосон хугацаанд тооцож, өргөсөн тангарагтаа үнэнч байх, цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой 26 төрлийн баталгааг давхардсан тоогоор 102 алба хаагчаас гаргуулан авч, хэрэгжилтийг хангуулж ажилласан нь алба хаагчдыг сахилга, хариуцлага дээшлэх нэг хүчин зүйл боллоо.

Тайлангийн хугацаанд 21 алба хаагчид Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, ёс зүйн дүрмийн дагуу сахилгын шийтгэл оногдуулсан бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 5 алба хаагч буюу 31.3 хувиар өссөн.

Сахилгын зөрчлийн 10 буюу 47.6 хувийг дотоод хяналтаар илрүүлсэн.

1.11. Санхүүгийн үйл ажиллагааны талаар.

1. Цагдаагийн газрын 2022 оны нийт төсөв 2.871.000.700 төгрөг бөгөөд санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтанд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй бөгөөд Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажилласан.

2. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон журнал, ерөнхий дэвтэрийг бүрэн хөтөлж, бараа материалын тайлан, үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл, бусад тайланг сар, улирал бүр гаргаж, цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцүүлэн, үр дүнг тооцон, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулан, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн.

1.12. Тайлангийн хугацаанд зохион байгуулсан, шинэлэг ажил, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар.

1. Цагдаагийн газар, алба хаагчдаас гаргасан амжилтыг бататгах, алба хаагчдын албандаа хандах эерэг хандлага, хамт олны уур амьсгалыг төлөвшүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчдыг хөгжүүлэх зорилгоор 2022 онд зохион байгуулах “Амжилтын төлөө хамтдаа” аяны удирдамж, төлөвлөгөөг Цагдаагийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/11 дугаар тушаалаар баталж, хэрэгжилийг хангуулан ажиллаж байна.

Аяны удирдамж, төлөвлөгөөний хүрээнд нийт 18 төрлийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэнээр гаргасан амжилтыг бататгаж, алба хаагчдын сэтгэлгээ, хандлагад эерэг өөрчлөлт гарч төлөвшиж, гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон алба хаагчийн тоо буурч, хариуцлага нэмэгдэж, хамт олны эерэг уур амьсгал бүрдэнэ гэж дүгнэж байна.

2. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан алба хаагч, ажилчдын гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, санал бодлыг сонсох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 06-ны өдөр цагдаагийн газрын алба хаагч, ажилчдын гэр бүлийн гишүүдийн төлөөлөлийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр цагдаа, дотоодын цэрэг болон цагдаагийн газрын үйл ажиллагаа, онцлогын талаар мэдээ, мэдээлэл өгч, ойлгуулан таниулсан болно.

Уулзалтын үеэр алба хаагч, ажилчдын гэр бүлийн 3 гишүүнд цагдаагийн газрын даргын “Талархал”, 5 гишүүнд “Ару” гоо сайхны газраас үйлчилгээ авах эрхийн бичгийг тус тус олгосон.

- “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан 17 алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг сонсож, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр санал солилцож, ард иргэдийнхээ амар тайван байдлыг хангаж ажиллаж буй алба хаагч нарын түшиг тулгуур болсон гэр бүлийн гишүүдтэй цагдаагийн газрын удирдлагын зүгээс талархалаа илэрхийлж, 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгуулагдах уран бүтээлийн тоглолтын билетийг гарын бэлгийн хамт гардуулсан.

3. Цагдаагийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар алба хаагчдад ярианы урлаг, бусдад өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх клубыг 7 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Мөн Цагдаагийн газрын дарга 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр алба хаагчдын ярианы урлагийн чадвар суулгах, бусдад өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, олж авсан мэдлэг, мэдээ, мэдээллийг бусдад түгээх арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг баталсан. Удирдамж, хуваарийн дагуу алба хаагчид уншсан ном, алба хаагчдыг хөгжүүлэх чиглэлээр олж авсан мэдээлэл болон улс орон, дэлхий дахинд болж буй үйл явдлын талаар дагуу долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагт нийт алба хаагч нарт сонсгол, мэдээлэл хийсэн болно.

4. Өнгөрсөн 2021 оны хөдөлмөрийн аварга, ажил, мэргэжилийн шилдэг, оны онцлох алба хаагчаар шалгарсан 15 алба хаагчид 45 төрөл бүрийн номыг

гардуулсан бөгөөд алба хаагчид уншсан номын талаар алба хаагч нарт сонсгол мэдээлэл хийж байгаа болно.

5. Цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчдын зөвлөлөөс Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тохиолдуулан “Спортлог”, “Авьяаслаг”, “Хийморлог”, “Тэвчээртэй”, “Найрсаг”, “Зүс төгөлдөр”, “Харилцааны соёлтой”, “Ноён нуруутай”, “Золбоотой”, “Хичээнгүй” зэрэг 10 төрлөөр алба хаагчдыг шалгаруулан батламж, дархлаа дэмжих амин дэм гардуулсан.

6. Цагдаагийн газрын удирдах 11 алба хаагчтай холбоотой “Удирдлагын арга барил ажилчдын сэтгэл ханамжид нөлөөлөх нь удирдах ажилтны арга барил ажилтнуудын сэтгэл ханамж тэдний уялдаа холбоог тодорхойлох зорилгоор нийт бие бүрэлдэхүүнээс 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр 20 асуулт бүхий санал асуулга авч, үр дүнд үндэслэн удирдах бүрэлдэхүүний тус бүрт зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулсан.

7. Хамт олны эв нэгдлийг хангах, алба хаагчдын итгэл үнэмшлийг бий болгох, түүгээрээ дамжуулан хариуцлага, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн гарын төв байранд шилэн “Баярлалаа”, “Уучлаарай” хайрцагийг байршуулан бөгөөд цагдаагийн газрын тасгийн дарга нар алба хаагч, ажилчдад хайрцагаар дамжуулан баярласан сэтгэгдлээ илэрхийлэх, захидал хүргэхээс гадна түүгээрээ дамжуулан санал, хүсэлтийг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгсөү бөгөөд өнөөдрийн байпдаар 2 алба хаагч бусдад талархах сэтгэгдлээ илэрхийлсэн болно.

Алба хаагчдын нийгмийн байдлын судалгааг тогтоох, удирдлагыг мэдээллээр хангах, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох зорилгоор нийт 18 асуулга бүхий санал асуулганд 124 алба хаагийг хамруулж, үр дүнг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн болно.

8. Цагдаагийн газрын үйл ажиллагааг сайжруулах, байгууллага, алба хаагчийг хөгжүүлэх, алба хаагчдын санал, хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор 3 асуулга бүхий санал асуулгыг 109 алба хаагч буюу нийт бие бүрэлдэхүүний 70.7 хувиас авч, дүнг нэгтгэн цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан алба хаагчдаас гаргасан санал, хүсэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор 31 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталж, хэрэгжүүлсэн.

9. Цагдаагийн газрын үйл ажиллагааны өнөөгийн байдал, алба хаагчдын ёс зүй, ажил, үйлчилгээний чанар, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор нийт 13 сум, 1 тосгоны 1357 иргэнээс 9 асуултын хүрээнд боловсруулсан санал асуулгыг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд авч, дүнг нэгтгэж Цагдаагийн газрын даргын 2022 оны 4 дэх хуралдаанаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч, иргэдээс гаргасан зарим саналыг хэрэгжүүлэхээр 11 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангасан.

Та цагдаагийн байгууллагын өнөөгийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгнө үү? гэсэн асуултанд 355 буюу 26 хувь нь үүргээ маш сайн гүйцэтгэж байгаа, 465 буюу 34 хувь нь үүргээ сайн гүйцэтгэж байгаа, 252 буюу 18.5 хувь нь хангалттай, 101 буюу 7.4 хувь нь хангалтгүй, 189 буюу 13.8 хувь нь зарим үйл ажиллагаанд онцгой анхаарах гэж тус тус хариулсан нь Цагдаагийн газрын үйл ажиллагаа иргэд, олон нийтэд жигд хүртээмжтэй хүрч байгаа гэж дүгнэхээр байна.

Цагдаагийн байгууллагын ажилчид үйл ажиллагаандаа юуг анхаарвал зохистой вэ? гэсэн асуултанд 707 буюу 52 хувь нь харилцааны соёл, 109 буюу 8 хувь нь ажлын ур чадвар, 151 буюу 11 хувь нь ёс зүй, 238 буюу 17.5 хувь нь шуурхай ажиллагаа, 232 буюу 17 хувь нь олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа гэж тус тус хариулсан нь алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэхээр байна.

10. Цагдаагийн газрын офицер, ахлагч бүрэлдэхүүний ажил, албандаа хандах хандлагыг дээшлүүлэх, чадавхжуулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт

олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Зорилгодоо хүрэх зөв хандлагыг хэвшил болгоё” сэдэвт зөвлөгөөнийг 2022 оны 09 дүгээр сарын 23, 10 дугаар сарын 21-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

11. Алба хаагч, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “OMRON” маркийн 1.000.000 төгрөгний өртөгтэй даралтын аппаратыг цагдаагийн газрын сэтгэл зүйчийн албан тасалгаанд байрлуулан ашиглаж байна.

12. Эрдэмтэн, судлаачдын багаар аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ судалгаа хийлгэхэд шаардагдах 8.000.000 /найман сая/ төгрөгний санхүүжилтийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсөвт суулган шийдвэрлүүлсэн бөгөөд судалгааны ажлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Прокурорын газар, Шүүхийн тамгын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Монголын криминологчдын холбоотой хамтран хийсэн.

Тухайлбал Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, криминологич Б.Батзориг тус аймагт 2022 оны 2 дугаар сард 7 хоног ажиллаж холбогдох судалгааг хийх, дээрх байгууллагуудын удирдлагуудтай уулзаж, судалгааны талаар санал солилцсон болно.

Судалгаа, дүн шинжилгээг хийснээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс тогтоогдож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээ тодорхойлогдож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой боловсруулан төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх, хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурах зэрэг ач холбогдолтой юм.

1.13. Бусад

1. Төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж яваад алтан амиа алдсан цагдаагийн ахлах ахлагч И.Эрдэнэшагайгийн намтар түүх, алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 30 дугаар зарлигаар “Шударга журам медаль”-иар нэхэн шагнасан.

2. “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, 15.2 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 тушаалаар баталсан “Иргэний зөвлөлийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллага, алба хаагчаас тайлан тавих /код 129/ журам”-ыг тус тус үндэслэн Цагдаагийн газрын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг аймгийн 12 сум, 1 тосгоны оршин суугчдад тайлагнах ажлыг 2022 оны 01 дүгээр дугаар сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 11-ны өдрийн хооронд өргөн хүргээд зохион байгуулсан ба бөгөөд тайлангийн хуралд нийт 1500 гаруй иргэн биечлэн оролцсон болно.

Мөн цагдаагийн газрын 2021 оны үйл ажиллагааны тайланг видео хэлбэрээр /7 минут 33 секунд/ бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл /7000 гаруй өрх үзэх боломжтой/-ээр болон цагдаагийн газрын албан ёсны цахим хуудас /baayan-ulgii.police.gov.mn/, “Баян-Өлгий Цагдаагийн газар” фейсбүүк, пейж хуудсанд /тус аймгийн иргэдийн 61 группын 200,000 орчим дагагчтай/ тус тус байшуулан сурталчилсан.

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ /код 947/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны “Ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/223 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Сар шинэ”, “Наурыз”-ын баяр болон “Ахмадын өдөр”-ийг угтан цагдаагийн газрын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг хүргүүлсэн.

Цагдаагийн газрын ахмад ажилтнуудын мэдлэг, ажлын арга барил, туршлагыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, уламжлуулах, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, гаргаж байсан алдаа, оноо, сургамж, зөвлөмжийг алба хаагчдад сурталчлан таниулах зорилгоор “Ахмадын оролцоо” арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, “Ахмад, дунд, залуу үеийн гурвалсан холбоог сайжруулах нь” уулзалтыг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр тус тус Цагдаагийн газарт зохион байгуулав.

Цагдаагийн газрын ахмад ажилтнуудын ажлын арга барил, туршлага, гаргаж байсан алдаа, оноо, сургамж, зөвлөмжийг зөвхөн цагдаагийн газрын алба хаагчдад сурталчлан таниулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталсан удирдамжийн дагуу нийт 12 ахмад ажилтныг оролцуулсан богино хэмжээний видео /шторк/ бэлтгэж, алба хаагчдад сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

4. Эмэгтэй алба хаагч, ажилчдад хүндэтгэл үзүүлэх, санал бодлыг сонсох, хамтын ажиллагааг сайжруулах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Цагдаагийн газрын эмэгтэй алба хаагч, ажилчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

5. Цагдаагийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр баталсан удирдамжийн дагуу алба хаагчдын ажлын стрессийг бууруулах, урлагийн авъяас билгийг нээн илрүүлэх, хөгжүүлэх, сурталчлан таниулах зорилгоор ажлын бүтээмж, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор “Ая дуу-2022” караоке дууны уралдааныг 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр “Цамбагарав” үйлчилгээний газарт зохион байгууллаа.

Дууны уралдаанд Удирдлага, Эрүүгийн цагдаагийн тасаг, Захиргааны удирдлагын тасаг, Мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шуурхай удирдлагын тасаг, Дотоодын цэргийн тусгай салаанаас гоцлол дууны төрөлд тус бүр 1 алба хаагч, 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй 8 баг тус тус оролцож, өрсөлдсөн.

6. Тайлангийн хугацаанд алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, авъяас ур чадварыг дээшлүүлэх, спортоор хичээллэх хандлагыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Олс таталт”, “Мөсөн шагайн харваа”, “Мөсөн сумо”, “Цагдаагийн газрын аварга шалгаруулах дартсны тэмцээн”, “Цагдаагийн газрын аварга шалгаруулах гар бөмбөгний тэмцээн”, “Би чадна”, “Аав, ээж, би”, “Хэн хурдан вэ”, “Цагдаагийн газрын аварга шалгаруулах аел бөмбөгний тэмцээн” гэсэн 9 төрлийн уралдааныг зохион байгуулсан.

- Цагдаагийн газрын даргын нэрэмжит цагдаа, дотоодын цэргийн ахмад ажилтан, алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн дунд “2022 ОНЫ СПОРТЫН ЦОГЦОЛБОР” тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөг, буудлага, дартс, ширээний теннис, шатар, даам, олс таталт гэсэн спортын 8 төрлөөр 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 19-ны хооронд зохион байгуулсан бөгөөд спортын цогцолбор тэмцээнд нийт 250 гаруй ахмад ажилтан, алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүд оролцсон болно.

Багийн нийлбэр дүнгээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг тэргүүн байр, Эрүүгийн цагдаагийн тасаг дэд байр, Захиргааны удирдлагын тасаг гуравдугаар байранд тус тус шалгарсан ба тэмцээнд амжилттай оролцсон тамирчдаас шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин, шилдэг тамирчин гэр бүл, шилдэг бяцхан тамирчинг шалгарууллаа.

- Баян-Өлгий аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 2022 оны аварга шалгаруулах “Спортын цогцолбор” тэмцээнд Цагдаагийн газрын баг, тамирчид “Дэд байр”-д шалгарсан.

- Алба хаагчдын биеийн дархлааг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Эрүүл биед саруул ухаан оршино” өдөрлөг зохион байгуулсан бөгөөд өдөрлөгийн үеэр явган аялал, 4 төрлийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд 250 гаруй алба хаагч, гэр бүлийн гишүүд хамрагдсан болно.

7. Монгол Улсад орчин цагийн Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээнд Цагдаа, дотоодын цэргийн 62 анги, байгууллагын эрэгтэй 102, эмэгтэй 80, нийт 182 алба хаагчид оролцсоноос тус цагдаагийн газрын алба хаагчидаас эрэгтэй ганцаарчилсан төрөлд 2 дугаар байр, эмэгтэй ганцаарчилсан төрөлд 8 дугаар байр, багийн дүнгээр 1 дүгээр байранд тус тус шалгарсан өндөр амжилт гаргасан болно.

- Улаанбатаар хотод болсон Улсын баяр наадмын үндэсний харвааны өмнөх сорилго, харваанд цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч Б.Энхтүвшин 1000 гаруй харваачдын дундаас 5 дугаар байранд шалгарсан өндөр амжилт гаргасан болно.

- Мөн Тулгар төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 101 жилийн түүхт ойн хүрээнд Үндэсний сурын харваанд эрэгтэй харваачдаас 40 сумнаас 37 сум онож гуравдугаар байр эзэлсэн Баян-өлгий аймгийн Өлгий сумын харьяат, Цагдаагийн ерөнхий газар, “Хүч” спорт хороо, Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газрын харваач, спортын мастер, цагдаа-жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Энхтүвшинд Монгол Улсын Ерөнхийлагчийн зарлигаар “Улсын гоц харваач” цол хүртээсэн.

- ХХ Зууны манлай дасгалжуулагч, Монгол Улсын Гавъяат дасгалжуулагч В.Батбаяр багшийн нэрэмжит Боксын насанд хүрэгчдийн 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээн Монгол бөхийн өргөөнд энэ оны гуравдугаар сарын 21-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөл тус цагдаагийн газрын харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Х.Бекнур +92 кг жинд өрсөлдсөн мөнгөн медаль хүртсэн өндөр амжилт гаргасан болно.

- Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөл, түүнийг арилгахад анхаарах асуудал” сэдэвт илтгэлийн анхдугаар уралдаанд Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ж.Жанболатын “Алба хаагчийн баталгаа” сэдвийн хүрээнд танилцуулсан илтэл “Тэргүүн байр”, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуультай хамтран зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал, онол, практикийн тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэлийн анхдугаар Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаагийн хошууч Х.Нурбекийн “Нойргүйдэл ба алба хаагчийн эрүүл мэндийн аюулгүй байдал” сэдэвт илтэл “Гутгаар байр”-нд тус тус шалгарсан бөгөөд тодорхой шинэлэг саналуудыг танилцуулсан болно.

- Аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн хэмжээнд төрийн алба хаагчдын дунд зохион байгуулсан “Манай байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх арга зам” сэдэвт итгэлийн уралдаанд Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ж.Жанболатын “Харилцаа” сэдвийн хүрээнд танилцуулсан илтэл “Тэргүүн байр”-д шалгарсан болно.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

1. Тайлангийн хугацаанд нууц далд аргаар үйлдэгдсэн урьд оны 90, энэ оны эхний 11 сарын байдлаар 126, нийт 216 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас 60 хэрэг, үйлдлийг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтай прокурорт шилжүүлсэн.

2. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 65.2 хувьтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар нэмэгдсэн.

3. Урьд өмнө нь үйлдэгдсэн яллагдагчаар татах этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийн нөхөн илрүүлэх болон шинээр бүртгэгдсэн нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх зорилгоор 19 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулан үр дүнг тооцов.

7. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх 22 заалт бүхий ажил, арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд мал хулгайлах 2022 оны эхний 11 сарын байдлаар 21 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 4.5 хувиар буурсан ба илрүүлэлт 71.4 хувьд хүргэсэн.

- Энэ оны эхний 11 сарын байдлаар үйлдэгдсэн мал хулгайн хэргээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэрэг бүртгэгдээгүй.

2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

1. 2022 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн гомдол мэдээлэл, шийдвэрлэлт:

Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 459 гомдол мэдээлэл хүлээн авч хуульд заасан үндэслэл журмын дагуу хойшлуулшгүй ажиллагаа явуулж шалгасан бөгөөд нийт хүлээн авч шалгасан гэмт хэргийн шинжтэй 126 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 62 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 262 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж тус тус шийдвэрлэсэн бөгөөд одоогийн байдлаар 16 гомдол мэдээлэлийн үлдэгдэлтэй. Нийт хүлээн авч шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 96.5 хувийг шийдвэрлэж тайлангийн хугацаанд гомдол мэдээлэл шалгах хугацаа хэтрүүлсэн зөрчил дутагдал гаргаагүй ажилласан.

2. Шалгаж шийдвэрлэсэн хэрэг бүртгэлтийн хэрэг:

Энэ хугацаанд 254 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 159 хэрэг буюу 62.5 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналаар прокурорт хүргүүлэн шийдвэрлэсэн бөгөөд 58 хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хаах саналтай шилжүүлж, 2 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, нийт 100 хэрэг бүртгэлтийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн байна. Одоо тус тасагт 31 хэргийн үлдэгдэлтэй, нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 87.7 хувийг шийдвэрлэсэн байна. Урьд оны хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлгүй байна. Хэрэг бүртгэлт явуулсан хэрэгт ажилласан мөрдөгчийн тоог дундажлахад 1 мөрдөгч 31 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/250 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг”-ийг баталсантай холбогдуулан тус цагдаагийн газраас бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

2. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Цагдаагийн байгууллагын 2022 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор тус

цагдаагийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 36 заалт бүхий ажил, арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулсан.

3. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр хурлаар салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ерөнхий, тусгай, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх чиглэлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сумдын ГХУСАЗСЗ-тэй хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, хуулинд заасан бусад чиг үүрэг зэрэг 7 чиглэлийн 90.000.000 төгрөгний санхүүжилттэй баталж, төлөвлөгөөнд цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр 13 ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. Цагдаагийн газрын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар Цагдаагийн газрын дүн шинжилгээ, судалгааны багийн бүрэлдэхүүнийг 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, аймгийн нутаг дэвсгэрт 2021 он, 2022 оны 01 дүгээр улиралд өссөн үзүүлэлттэй бүртгэгдсэн залилах, хулгайлах, мал хулгайлах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, хүүхэд холбогдсон гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөлийг судалж, арилгах арга хэмжээний саналыг боловсруулж, Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, гаргасан саналуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

5. Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн газар зүйн байршлын цахим зураглал бий болгох, /улаан, шар, ногоон бүсэд хуваах/ урьдчилан сэргийлэх ажилд ашиглах, гэмт хэрэг, зөрчилгүй бүс буюу ногоон бүсийн хүрээг тэлэх арга хэмжээг нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.

Урьдчилсан байдлаар 13 сум, 1 тосгоны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд уялдуулан Булган, Буянт, Дэлүүн, Толбо, Алтанцөгц сум, Цагааннуур тосгоныг ногоон бүс, Сагсай, Алтай, Баяннуур, Бугат, Улаанхус сумдыг шар, Өлгий, Цэнгэл, Ногооннуур сумдыг улаан бүсэд тус тус хамруулж, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа болно.

6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн 1 тогтоол, аймгийн Засаг даргын 6, сумдын 2 захирамжийг тус тус гаргасан.

7. Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 36 удаагийн нэгдсэн, 24 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ, 13 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт, 68 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 321 удаагийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, нэгдсэн үзлэг шалгалтад давхардсан тоогоор 48 ерөнхий боловсролын сургууль, 3 их, дээд сургууль, 1 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, 311 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 2315 ажилтан, 1130 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 1450 малчин иргэд, 390 оюутан, 3150 сурагч, 1120 ажилгүй иргэн, нийт 9555 хүн хамрагдсан.

Зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 110 байгууллагын 195 албан хаагч, ажилтнуудыг нийтийн эргүүлд татан оролцуулсан бөгөөд 21 зөрчил илрүүлж, шалгуулахаар эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн.

8. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгуулахаар нийт 212 мэдэгдэл, шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд 181 мэдэгдэл, шаардлагын хариуг авч, 24 мэдэгдэл, 16 шаардлагын хариуг газар дээр нь шалгах ажиллагаа явуулж ажилласан.

9. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар телевизээр 55 удаагийн буюу 266 минутын мэдээ, мэдээллийг 55 удаагийн

давталттай, радиогоор 42 удаагийн буюу 151 минутын мэдээ, мэдээллийг 42 удаагийн давталттай хүргэж, 296 мэдээ, мэдээллийг цахим орчинд байршуулан сурталчлав.

Мөн Цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэх зорилгоор Цагдаагийн газрын албаны хэрэгцээнд ашиглагдаж байгаа HD LED дэлгэц болон урсдаг LED самбарын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж, 46 удаа нийт 116 богино хэмжээний дуу, дүрс бичлэг, мэдээллийг байршуулан сурталчлав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 127 төрлийн 52400 ширхэг зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд тарааж, Цагдаагийн газрын Facebook хаягт байршуулан тус аймгийн иргэдийн хандалт ихтэй 15627 группд түгээлт хийсэн бөгөөд давхардсан тоогоор 550000 орчим хүн хандалт авсан.

10. Цагдаагийн газраас 246 төрийн байгууллага, 71 төрийн бус байгууллага, 64 аж ахуйн нэгж байгууллага, 81 малчдын бүлгэм, 18 хөршийн хяналтын бүлгэм, 14 ерөнхий боловсролын сургуулийн эргүүл, 14 өсвөрийн сэргийлэгч бүлгэм, 12 сум, 1 тосгоны хамтарсан багийн нийт 1356 гишүүнийг 688 удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан.

2.4. Замын цагдаагийн албаны чиглэлээр

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Тээврийн цагдаагийн алба, Цагдаагийн газраас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төлөвлөсөн ажил, арга хэмжээг зохион байгуулан биелэлт үр дүнг тооцов.

2. Замын цагдаагийн тасгаас Зам тээврийн осол, хэрэг, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 онд хэрэгжүүлэх 32 төрлийн ажил, арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Цагдаагийн газраас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нэгдсэн арга хэмжээ 2, хэсэгчилсэн арга хэмжээ 30, аян 1, нийт 33 арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцов.

Тухайлбал:

“Хар цэг”, “Тусгай дуут болон гэрлэн дохио”, “Сар шинэ” “Гэрлэн дохио камер” “Тэмдэг тэмдэглэл техник хэрэгслийн үзлэг тооллого”, “Улсын дугаар”, “Мотоцикл”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал ачаа тээвэр”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Оношилгоо”, “Явган зорчигч”, “Хүүхдийн аюулгүй тээвэр”, “Татвар”, “Орон нутгийн хөдөлгөөний соёл”, “Сургуулийн бүс”, “Эмзэг цэг”, “Оюутан тээвэр”, “Зорчигч тээвэр”, “Ургац-2022”, “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа”, “Халтиргаа”, “Хамгаалах малгай”, “Тээврийн хэрэгслийн өнгөт хальс тенг”, “Уусан бол бүү жолоод” “Сургууль орчмын бүс хүүхэд”, “Гэрлээр анхааруулъя”, “Сурагчийн аюулгүй байдал эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо”, “Гар утас”, “Согтуу”, “Явган хүний гарц”, “Ес дүгээр сарын нэгэн”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл цагаан шугам”, “Аажуу явдал аяндаа хүрнэ дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Өлгий-Ховд аймаг чиглэлийн А0306 дугаартай олон улсын болон улсын чанартай авто замд давхардсан тоогоор 150 удаа давхардсан тоогоор 180 алба хаагч хөдөлгөөнт байдлаар хяналт шалгалт хийж, уг замаар хөдөлгөөнд оролцож явсан 15.000 орчим тээврийн хэрэгслийг шалгаж, 8000 гаруй сэрэмжлүүлэг материал тараасан. Тухайлбал:

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны хүрээнд энэ оны 11 дүгээр сард ашиглалтад орох “Цагааннуур-Улаанбайшинт”

чиглэлийн авто замд дундаж хурдны теле хяналтын камер суурилуулахад шаардагдах 212.938.000, сургуулийн орчмын бүсэд тэмдэг, тэмдэглэгээ хийлгэхэд шаардагдах 40.000.000, аймгийн суурин газруудын талаарх мэдээлэл байршлыг мэдээлэх самбарт шаардагдах 50.000.000, Өлгий-Ховд-Цагааннуур чиглэлийн А/0305, А/0306 дугаартай авто зам дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүл, хяналт шалгалтад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажиллах орчныг сайжруулах, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх 4 ширхэг пост хийхэд шаардагдах санхүүжилт болох 51.000.000, Улаанбайшинтын боомтын суурины орчимд 2 авто зогсоолыг барихад шаардагдах 590.400.000 төгрөг, нийт 944.338.000 төгрөгийн төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Иргэд, байгууллагаас 855 тооны гомдол, мэдээлэл хүлээн авч, 164 материалд зөрчлийн хэрэг нээж, 683 материалыг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба 8 гомдол, мэдээллийг шалгаж байна

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн хяналт, шалгалтад 14 удаа татан оролцуулж, давхардсан тоогоор Замын цагдаагийн чиглэлээр 1100 гаруй алба хаагч 1300 гаруй цагийн үүрэг гүйцэтгэж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн нийт 14.927 зөрчил илрүүлэн, 14.927 хүнийг 343.600.000 торгож хариуцлага тооцов.

3. Замын цагдаагийн тасгийн алба хаагч нар замын хөдөлгөөнийг зохицуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд аймгийн төвийн 38 цэгт байрлалтай 52 телехяналтын камер, 5 ширхэг согтуурал шалгах багаж, 2 ширхэг хурд хэмжигч, 4 ширхэг хөдөлгөөнт эргүүлийн автомашин, 7 ширхэг энгэрийн камер, 12 ширхэг бэлэн бус торгуулийн багаж, шалгах төхөөрөмж зэрэг техник хэрэгслийг ашиглан замын хөдөлгөөнд хяналт тавьж, 14.927 зөрчил илрүүлсэн.

Үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 669 хүнийг илрүүлэн, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 156 хүнийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлуулан, 513 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаатай хасаж, 205.200.000 төгрөгөөр, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 350 жолоочийг 70.000.000 төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ авч ажилласан.

Энэ оны эхний 11 сарын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн улмаас 4 хүний амь нас хохирсон бөгөөд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 6 хүнээр буюу 60 хувиар буурсан.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 21 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 5 гэмт хэрэг буюу 31.2 хувиар нэмэгдсэн.

2.5. Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:

1. Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй 55 эмзэг цэгийг объектын судалгаанд авч, эргүүлийн байршилтыг Цагдаагийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/56 дугаар тушаалаар шинэчлэн батлуулан гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд хяналт тавих эргүүлийн чиглэлийг эргүүлийн нэгдсэн байршилтад тусган баталгаажуулж байршилтын дагуу өдөр тутмын эргүүлийн томилгоог хийж, эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн зөрчлийн илрүүлэлтийг дээшлүүлсэн бөгөөд энэ оны эхний 11 дүгээр сарын байдлаар 18319 зөрчил илрүүлсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2692 зөрчил буюу 17.2 хувиар нэмэгдсэн.

2. Тус хугацаанд нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр авто эргүүлийн 161 чиглэлд 322 алба хаагч, явган эргүүлийн 641 чиглэлд 1284 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 698 хүн, 469 объект, 626 тээврийн хэрэгслийг шалгаж, жижүүрийн албанд ирсэн 2050 дуудлага мэдээллийн дагуу хүрэлцэн очиж, архидан согтуурсан

886 хүнийг ар гэрт нь, 704 хүнийг эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээлгэн өгсөн. Эргүүлийн хяналтаар 2733 зөрчил илрүүлснээс 2527 зөрчилд хялбаршуулсан журмаар 75.208.100 төгрөгийн торгууль оногдуулж, 388 зөрчлийг шалгуулахаар эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн өгсөн.

3. Гудамж талбайд үйлдэгдсэн 15 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 хэргээр буюу 40 хувиар, согтуугаар үйлдэгдсэн 31 гэмт хэрэг бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 6 хэргээр буюу 14.6 хувиар тус тус буурсан, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 27 бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 33.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4. Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан “Сар шинэ”, “Зөвийг зөвлөө”, “Аажуу явбал аяндаа хүрнэ”, “Илрүүлэлт-Оргодол 2022” зэрэг нэгдсэн арга хэмжээ, “Хичээлийн амралт”, “Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлье”, “Гэр хороолол”, “Хяналт шалгалт”, “Захирамжийн хэрэгжилт”, “Хуулийн хэрэгжилт”, “Акц”, “Сайн хөршийн холбоо”, “Архидалтгүй ирээдүйн төлөө”, “Нэг офицер-нэг өрх”, “Хичээл эхэллээ” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, хэв журам болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 12 удаагийн нэгдсэн эргүүл зохион байгуулж давхардсан тоогоор 467 алба хаагчийг томилон ажиллуулсан.

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/246 тоот тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/63, 70 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албадан эрүүлжүүлэх /код-629/ журам”-ын хэрэгжилтийг хануулан ажиллаж байна.

Тус хугацаанд цагдаагийн газрын эрүүлжүүлэх байранд 506, баривчлах байранд 419, саатуулах байранд 198 хүнийг хүлээн авсан ба эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн тохиолдол бүртгэгдээгүй.

6. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах харуулын цагдааг 24 цагаар томилж өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан. Шүүхийн харуулын цагдаа нар шүүхээр үйлчлүүлсэн нийт 5053 иргэнийг бүртгэж, Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх мэргэжлийн байгууллагуудаас тогтоосон хорио цээрийн дэглэмийг сахиулж шүүхийн байранд нэвтрүүлж холбогдох албан тушаалтантай нь уулзуулж ажилласан.

Хамгаалалтын цагдаа болон нэмэлтээр томилогдсон харуулын цагдаа нар тайлангийн хугацаанд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны эрүүгийн 328, зөрчлийн хэргийн 530, иргэний хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд иргэний 1239 Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд захиргааны 106 нийт 220 шүүх хуралдаанд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж, шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх хуралдаанд журам сахиулж шүүх хуралдааны танхимаас нийт 228 гэрчийг тусгаарлаж ажилласан.

Эрүүгийн хэргийн шүүхээс ял авсан мөн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорихоор шийдвэрлэсэн 64, цагдан хорих байранд хоригдож байгаа яллагдагч, шүүгдэгч 50, нийт 114 шүүгдэгчийг шүүхээс цагдан хорих байранд, цагдан хорих байрнаас шүүхэд хуяглан хүргэсэн. Мөн албадан ирүүлэх шүүгчийн захирамжаар эрүүгийн хэргийн холбогдогч 6, зөрчлийн хэргийн холбогдогч 12, нийт 18 хүнийг албадан ирүүлж шүүхийн байгууллагад хүлээлгэн өгсөн.

2.6. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

1. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх 3177 омдол, мэдээлэл хүлээн авч шалгасан ба урьд оны үлдэгдэл 17 гомдол мэдээлэл нэмэгдээд нийт 3089 гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн.

Нийт 3177 гомдол мэдээллээс гэмт хэргийн талаарх 722, зөрчлийн талаарх 2455 гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд одоо үлдэгдэл 89 гомдол, мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдлоос 682 буюу 94.4 хувийг шийдвэрлэсэн бөгөөд 289 буюу 42.3 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 387 гомдол буюу 56.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 4 буюу 0.5 хувийг харьяаллын дагуул шилжүүлж шийдвэрлэв.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 98.6 хувийг 5-19 хоногт шийдвэрлэж шалгуур үзүүлэлтийг хангасан.

2. Нийт бүртгэгдсэн 314 гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгжид 971.1 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт учирсан хохирлын 698.2 сая төгрөг буюу 71.9 хувийг нөхөн төлүүлсэн ба өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 19.0 хувиар өсч, 278.6 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн.

2.7 Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1. Цагдаагийн газрын хэмжээнд иргэд, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн зөрчлийн шинжтэй 2316 гомдол, мэдээлэл хүлээн авч, 318 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 614 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1325 гомдлыг хялбаршуулсан журмаар, 10 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн. Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол, мэдээлэл байхгүй.

2. Гомдол, мэдээлэл гаргасан иргэд, аж ахуйн нэгжид 100 хувь бичгээр хариу өгсөн. Иргэдэд өгч буй хариу мэдэгдэх хуудсанд гомдол, мэдээлэл гаргагчаар хүлээн авсан талаар гарын үсэг зуруулан хувийг авч, гомдол гаргагчид хариу өгсөн эсэхэд хяналт тавьж байна. Иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, хариу өгсөн байдалтай холбоотой санал, гомдол ирүүлээгүй.

Тайлангийн хугацаанд нийт 22 зөрчлийн хэргийн үлдэгдэлтэйгээс 13 хэрэг Замын цагдаагийн тасгийн, 9 хэрэг Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн харьяалалтай байна. Мөн энэ хугацаанд Зөрчлийн 639 хэрэг шалгаж, 498 хэргийг албадлагын арга хэмжээ авхуулах саналтай шүүхэд шилжүүлж, 423 холбогдогчийг 7-30 хоногоор баривчлуулан, 73 хэргийн 75 холбогдогчийг шүүхээс торгож, 106 зөрчлийн хэрэгт холбогдсон 121 холбогдогчийг эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэл оногдуулсан бөгөөд 20 хэргийг хэрэгсэхгүй болгож 11 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн.

3. Зөрчлийн хэрэг нээсэн хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 163 хэрэг буюу 36.1 хувиар өссөн. Нийт шалгасан зөрчлийн хэргийн шийдвэрлэлт 96.5 хувьтай байна. Энэ онд бүртгэгдсэн зөрчлийн хэргийн илрүүлэлт 96.4 хувьтай байна.

Зөрчлийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид учирсан 95.2 сая төгрөгийн хохирлыг 100 хувь нөхөн төлүүлж, зөрчил үйлдэж хууль бусаар олсон орлого болох 157.400 төгрөг, зохих зөвшөөрөлгүйгээр худалдан борлуулсан 54 литр архи, 118 литр шар айраг, 8380 ширхэг тамхийг тус тус хураан авч улсын орлого болгосон.

4. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах асап сангаар зөрчил үйлдсэн 17 этгээдийг эрэн сурвалжилсан 17 этгээдийг олж тогтоосон

5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, 7-30 хоногийн хугацаатай баривчлагдсан 120 иргэнд баривчлах байранд байх хугацаанд дахин зөрчил үйлдэхгүй байх, холбогдогч нарын хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 6 удаа 6

цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан бөгөөд уг сургалтад давхрадсан тоогоор 120 иргэн хамрагдсан.

2.8 “Цагааннуур” чөлөөт бүсийг хамгаалах Дотоодын цэргийн гэрээт 829 дүгээр тусгай салбарын үйл ажиллагааны чиглэлээр:

1. Улсын онц чухал объектын хамгаалалтыг Монгол Улсын хууль тогтоомж, Дотоодын цэргийн командлагчийн баталсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааг 2022 онд зохион байгуулах удирдамж”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, Дотоодын цэргийн штабын дарга, Цагдаагийн газрын дарга нарын нарын өгсөн үүрэг, ажлын чиглэлийн дагуу хуулиар тогтоосон үүргээ бүрэн хэрэгжүүлж, алба-ажиллагааг хууль тогтоомж, дүрэм, стандарт, үйл ажиллагааны журмаар зохион байгуулсан.

ЦАГДААГИЙН ГАЗАР